



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

᠒᠐᠒᠐ оны 11 сарын ᠒᠐ өдөр

Дугаар 21᠐


Улаанбаатар хот

Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.14 дэх заалт, "Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам"-ын 2.4, Худалдан авах ажиллагааны ахлах байцаагч, улсын байцаагч нарын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах этгээдийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийн мэдээллийг худалдан авах ажиллагааны цахим системд олон нийтэд нээлттэй байршуулахыг Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэс /Ц.Батзул/-т, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг захиалагч нарт даалгасугай.



Ч.ХҮРЭЛБААТАР

9767000393

Сангийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 20-ны
өдрийн 210 дугаар тушаалын хавсралт

Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд
хамруулах этгээдийн жагсаалт

№	Эрхээ хязгаарлуулсан этгээдийн нэр, регистрийн дугаар	Бүртгэлд хамруулсан үндэслэл	Улсын байцаагчийн шийдвэр, шүүхийн тогтоолын дугаар, огноо	Бүртгэлд хамруулсан огноо
1	“Дээвэр констракшн” ХХК /РД: 5391032/	Нотариатын тамга, засварлаж, хуурамчаар үйлдсэнийг улсын байцаагч тогтоосон.	Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн 2020.10.23-ны өдрийн УБ/34 дугаар дүгнэлт	2020 оны 11 дугаар сарын 20-ны өдөр
2	“Эс Жи Эм” ХХК /РД:5916569/	Нийгмийн даатгалын НД-8 тайланг засварлаж, хуурамчаар үйлдсэнийг улсын байцаагч тогтоосон.	Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн 2020.10.23-ны өдрийн УБ/35 дугаар дүгнэлт	2020 оны 11 дугаар сарын 20-ны өдөр
3	“Мөнх цаст жаргалант” ХХК /РД: 6158714/	Хөдөө аж ахуйн их сургуулийн D200905665 дугаар дипломыг хуурамчаар үйлдсэнийг улсын байцаагч тогтоосон.	Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн 2020.10.23-ны өдрийн УБ/32 дугаар дүгнэлт	2020 оны 11 дугаар сарын 20-ны өдөр